



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/5/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.25 № 356
танай _____-ны № _____-т

ГУРВАНЗАГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.БАТДЭЛГЭР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Гурванзагал сумын нэгтгэсэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын нэгтгэсэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гурванзагал сумын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 80,0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.




Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	462,141,051.41	650,395,593.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	81,897,322.96	247,110,709.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	81,897,322.96	247,110,709.02
3121	Төгрөг	81,897,322.96	247,110,709.02
31211	Төрийн сангийн харицах	80,964,052.05	245,337,311.45
31213	Арилжааны банк дахь харицах	933,270.91	1,773,397.57
33	АВЛАГА	185,008,198.00	160,596,263.42
335	Бусад авлага	185,008,198.00	160,596,263.42
3351	Байгууллагаас авах авлага		934,887.42
3352	Хувь хүмүүсээс авах авлага	185,008,198.00	159,661,376.00
35	БАРАА МАТЕРИАЛ	195,235,530.45	242,688,620.69
351	Түүхий эд материал	6,406,143.73	23,854,292.01
35110	Тусгай зориулалттай материал	4,109,000.00	7,599,048.00
35130	Эм боох материал	2,297,143.73	16,255,244.01
354	Хангамжийн материал	110,167,199.22	137,177,203.68
35410	Бичиг хэргийн материал	8,472,561.55	11,768,326.12
35420	Аж ахуйн материал	81,821,896.66	95,707,814.56
35440	Түлш, шатах тослох материал	6,039,799.51	509,550.00
35450	Барилгын засварын материал		12,967,528.00
35460	Хүнсний материал	7,445,135.50	4,386,179.00
35470	Бусад хангамжийн материал	6,387,806.00	11,837,806.00
35500	Биологийн хөрөнгө		946,000.00
35600	Мал амьтад	78,662,187.50	80,711,125.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,840,346,036.63	3,156,826,502.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,840,346,036.63	3,156,826,502.51
392	Биет хөрөнгө	2,749,437,785.01	3,066,257,690.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,096,271,330.62	2,418,499,510.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(160,790,787.19)	(208,183,103.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,625,151.00	126,754,639.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,009,867.60)	(73,902,783.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,858,536.24	366,816,615.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(156,751,225.70)	(191,193,935.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	134,767,724.77	140,410,434.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,068,365.49)	(76,877,724.76)
39209	Зам, гүүрийн байгууламж	343,201,868.90	343,201,868.90
39210	Хуримтлагдсан элэгдэл	(145,525,977.25)	(167,064,906.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	524,286,745.17	627,191,109.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	(200,166,728.46)	(248,133,412.27)
39217	Ном	8,739,380.00	8,739,380.00
393	Биет бус хөрөнгө	90,908,251.62	90,568,811.58
39301	Програм хангамж	3,114,800.00	2,897,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,832,356.69)	(1,954,196.73)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,138,000.00	90,138,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(512,191.69)	(512,191.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,302,487,088.04	3,807,222,095.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,830,285.00	723,708.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,830,285.00	723,708.04
413	Өглөг	2,830,285.00	723,708.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,797,854.00	691,277.04
4136	Бусад өглөг	32,431.00	32,431.00
41361	Байгууллагад төлөх өглөг	32,431.00	32,431.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,299,656,803.04	3,806,498,387.60
51	Засгийн газрын хувь оролцоо	3,299,656,803.04	3,806,498,387.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,367,688,107.72	1,367,688,107.72
512	Хуримтлагдсан үр дүн	876,862,106.45	1,383,703,691.01
51210	Өмнөх үеийн үр дүн	648,546,491.17	876,862,106.45
51220	Тайланг үеийн үр дүн	228,315,615.28	506,841,584.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,055,106,588.87	1,055,106,588.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,302,487,088.04	3,807,222,095.64



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,313,172,097.78	2,525,956,448.13
11	ТАТВАРЫН ОРЛОГО	36,511,687.76	43,349,137.34
110	Орлогын албан татвар	34,085,274.76	41,279,714.34
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,085,274.76	41,279,714.34
110002	Үйл ажиллагааны орлого	9,370,986.71	11,469,348.10
110003	Хөрөнгийн орлого		13,183,251.27
110008	Шууд бус орлого	24,714,288.05	16,627,114.97
113	Хөрөнгийн албан татвар	1,080,000.00	840,000.00
113002	Бууны албан татвар	1,080,000.00	840,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,346,413.00	1,229,423.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,346,413.00	1,229,423.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,346,413.00	1,229,423.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	346,397,953.65	611,152,237.79
120	Нийтлэг татварын бус орлого	346,397,953.65	611,152,237.79
120002	Хүүгийн орлого	10,789,066.57	1,376,372.00
120003	Торгуулийн орлого	23,516,929.74	2,538,265.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,564,455.20	18,523,831.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,710,615.20	7,907,706.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	8,002,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,853,840.00	2,613,625.00
120009	Бусад орлого	516,000.00	44,034,510.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө	236,093,919.00	519,265,900.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Бараа материал	12,917,583.14	25,413,359.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,930,262,456.37	1,871,455,073.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	796,463,100.00	993,558,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	796,463,100.00	993,558,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,646,404.00	218,190,003.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,755,354.00	217,890,003.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	2,891,050.00	300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,023,111,952.37	648,482,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан	437,188,300.00	560,735,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	102,622,600.00	87,747,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,041,000.00	11,224,170.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,041,000.00	11,224,170.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,995,544,093.50	1,926,782,080.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,995,544,093.50	1,926,782,080.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,498,083,324.51	1,865,433,261.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,725,951.07	1,048,205,743.85
210101	Үндсэн цалин	723,055,508.17	779,403,689.89
210102	Нэмэгдэл	62,555,592.20	195,557,159.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,601,811.00
210104	Урамшуулал	45,114,850.70	69,643,083.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,351,191.31	140,781,101.13
210201	Тэтгэврийн даатгал	71,376,191.31	93,319,601.13
210202	Тэтгэмжийн даатгал	8,399,100.00	10,615,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,879,300.00	8,223,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,700,700.00	6,032,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,995,900.00	22,589,900.00



Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,088,209.06	87,436,687.40
210301	Гэрэл, цахилгаан	16,901,599.50	16,992,770.89
210302	Түлш, халаалт	79,725,209.56	64,607,616.51
210303	Цэвэр, бохир ус	3,461,400.00	5,836,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,355,077.00	65,209,154.00
210401	Бичиг хэрэг	9,712,283.00	10,120,400.00
210402	Тээвэр, шатахуун	44,822,479.00	39,551,977.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,297,400.00	6,585,670.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	1,729,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,762,915.00	7,221,230.00
2105	Нормативт зардал	69,496,142.83	79,415,340.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,565,132.83	39,201,079.82
210502	Хоол, хүнс	45,306,010.00	39,064,708.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	625,000.00	1,149,552.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,604,500.00	6,455,387.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	699,000.00	2,382,187.50
210604	Урсгал засвар	22,905,500.00	4,073,200.00
2107	Томилолт, зочны зардал	12,760,760.00	7,228,000.00
210702	Дотоод албан томилолт	12,760,760.00	7,228,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,180,217.60	23,115,308.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,350,432.00	21,051,623.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	433,000.00	1,170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	608,917.00	168,405.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	326,000.00	318,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	410,840.00	33,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	197,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	31,028.60	176,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,521,275.64	407,586,539.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,163,975.00	221,327,651.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,590,160.00	2,020,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	169,767,140.64	184,238,888.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	497,460,768.99	61,348,819.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,159,716.62	31,006,682.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,952,816.50	7,737,312.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,453,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,862,000.00	6,816,070.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	30,342,137.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		30,342,137.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	317,628,004.28	599,174,367.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,312,389.00	92,332,782.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		24,180,136.73
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	89,312,389.00	68,152,646.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(89,312,389.00)	(92,332,782.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	228,315,615.28	506,841,584.56



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,040,459,623.64	2,004,410,385.73
11	ТАТВАРЫН ОРЛОГО	36,511,687.76	43,349,137.34
110	Орлогын албан татвар	34,085,274.76	41,279,714.34
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,085,274.76	41,279,714.34
110002	Үйл ажиллагааны орлого	9,370,986.71	11,469,348.10
110003	Хөрөнгийн орлого		13,183,251.27
110008	Шууд бус орлого	24,714,288.05	16,627,114.97
113	Хөрөнгийн албан татвар	1,080,000.00	840,000.00
113002	Бууны албан татвар	1,080,000.00	840,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,346,413.00	1,229,423.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,346,413.00	1,229,423.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,346,413.00	1,229,423.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,685,479.51	82,203,675.39
120	Нийтлэг татварын бус орлого	73,685,479.51	82,203,675.39
120002	Хүүгийн орлого	10,789,066.57	1,376,372.00
120003	Торгуулийн орлого	23,516,929.74	2,538,265.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,863,483.20	34,254,528.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,863,483.20	33,654,528.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	600,000.00
120009	Бусад орлого	516,000.00	44,034,510.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,930,262,456.37	1,878,857,573.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	796,463,100.00	993,558,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	796,463,100.00	993,558,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,646,404.00	225,592,503.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,870,354.00	218,190,003.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,776,050.00	7,402,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,023,111,952.37	648,482,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	437,188,300.00	560,735,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	102,622,600.00	87,747,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,041,000.00	11,224,170.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,041,000.00	11,224,170.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,833,916,209.10	1,757,377,783.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,833,916,209.10	1,757,377,783.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,337,024,056.73	1,696,070,276.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	834,693,151.07	1,050,004,710.23
210101	Үндсэн цалин	726,601,094.17	775,944,254.76
210102	Нэмэгдэл	62,977,206.20	200,815,559.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,601,811.00
210104	Урамшуулал	45,114,850.70	69,643,084.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,318,400.00	142,423,599.13
210201	Тэтгэврийн даатгал	71,343,400.00	94,962,099.13
210202	Тэтгэмжийн даатгал	8,399,100.00	10,615,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,879,300.00	8,223,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,986,400.00	6,032,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,710,200.00	22,589,900.00



Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,393,149.06	84,304,810.89
210301	Гэрэл, цахилгаан	16,901,599.50	17,035,974.89
210302	Түлш, халаалт	79,030,149.56	61,432,536.00
210303	Цэвэр, бохир ус	3,461,400.00	5,836,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,111,896.00	60,198,569.00
210401	Бичиг хэрэг	9,802,883.00	9,751,600.00
210402	Тээвэр, шатахуун	42,511,496.00	33,519,892.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	7,523,000.00	6,585,670.00
210404	Ном, хэвлэл	283,500.00	520,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	1,729,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,261,017.00	8,091,530.00
2105	Нормативт зардал	76,058,400.00	74,878,142.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,427,000.00	29,878,200.00
210502	Хоол, хүнс	52,997,000.00	33,524,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,634,400.00	11,475,552.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,272,400.00	15,736,210.00
210601	Багаж, техник хэрэгсэл	699,000.00	2,348,010.00
210604	Урсгал засвар	18,573,400.00	13,388,200.00
2107	Томилолт, зочны зардал	12,760,760.00	7,228,000.00
210702	Дотоод албан томилолт	12,760,760.00	7,228,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,704,300.60	24,316,308.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,656,932.00	21,982,623.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	613,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	609,000.00	168,405.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,500.00	318,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	410,840.00	33,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	197,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	31,028.60	176,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,711,600.00	236,979,927.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,364,240.00	233,094,927.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,347,360.00	3,885,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	496,892,152.37	61,307,507.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,591,100.00	30,965,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,729,100.00	7,696,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,453,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,862,000.00	6,816,070.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	30,342,137.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		30,342,137.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	206,543,414.54	247,032,602.06
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	138,938,689.00	81,819,216.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,938,689.00	81,819,216.00
2200	Дотоод эх үүсвэрээр	138,938,689.00	81,819,216.00
223001	Бусад хөрөнгө	89,312,389.00	68,152,646.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,626,300.00	13,666,570.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(138,938,689.00)	(81,819,216.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(12,395,274.46)	165,213,386.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94,292,597.42	81,897,322.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	81,897,322.96	247,110,709.02



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	647,786,491.28	3,070,581,187.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			759,999.89	759,999.89
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	648,546,491.17	3,071,341,187.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			228,315,615.28	228,315,615.28
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	876,862,106.45	3,299,656,803.04
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	876,862,106.45	3,299,656,803.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	876,862,106.45	3,299,656,803.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00		0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	506,841,584.56	506,841,584.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,688,107.72	1,055,106,588.87	1,383,703,691.01	3,806,498,387.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,790,959,400.00	1,579,813,815.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,628,559,400.00	1,509,681,169.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,597,410,100.00	1,478,715,799.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,075,227,600.00	1,048,556,310.23
210101	Үндсэн цалин	823,599,700.00	775,944,254.76
210102	Нэмэгдэл	168,199,200.00	200,815,559.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,927,100.00	3,601,811.00
210104	Урамшуулал	79,501,600.00	68,194,684.76
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,423,600.00	142,423,599.13
210201	Тэтгэврийн даатгал	97,613,000.00	94,962,099.13
210202	Тэтгэмжийн даатгал	10,150,900.00	10,615,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,544,500.00	8,223,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,430,000.00	6,032,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,685,200.00	22,589,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,256,000.00	81,581,166.85
210301	Гэрэл, цахилгаан	15,623,200.00	14,312,330.85
210302	Түлш, халаалт	61,387,400.00	61,432,536.00
210303	Цэвэр, бохир ус	6,245,400.00	5,836,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,236,300.00	58,719,619.00
210401	Бичиг хэрэг	11,807,100.00	9,751,600.00
210402	Тээвэр, шатахуун	38,766,000.00	32,040,942.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,618,000.00	6,585,670.00
210404	Ном, хэвлэл	562,000.00	520,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	1,730,000.00	1,729,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,753,200.00	8,091,530.00
2105	Нормативт зардал	76,164,800.00	62,801,742.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,485,800.00	19,501,800.00
210502	Хоол, хүнс	41,179,000.00	31,824,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,500,000.00	11,475,552.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,050,000.00	25,529,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,700,000.00	11,254,580.00
210604	Урсгал засвар	28,350,000.00	14,275,000.00



Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	9,748,200.00	6,976,000.00
210702	Дотоод албан томилолт	9,748,200.00	6,976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,850,700.00	23,834,608.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	29,005,200.00	21,682,623.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,410,000.00	1,320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	174,500.00	168,405.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,600.00	283,080.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	624,400.00	197,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	155,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,452,900.00	28,293,174.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,804,700.00	24,408,174.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,648,200.00	3,885,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,149,300.00	30,965,370.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,149,300.00	30,965,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,696,000.00	7,696,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,453,300.00	16,453,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	6,816,070.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	111,900,000.00	70,132,646.00
2200	Дотоод эх үүсвэрээр	111,900,000.00	70,132,646.00
223001	Бусад хөрөнгө	111,900,000.00	70,132,646.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,500,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,790,959,400.00	1,630,313,097.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	991,796,300.00	963,216,262.58
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	991,796,300.00	963,216,262.58
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	679,112,500.00	624,368,136.63
132001	Орон нутгийн төсвөөс	591,365,100.00	536,620,736.63
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	87,747,400.00	87,747,400.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,298,000.00	11,224,170.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,298,000.00	11,224,170.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	105,752,600.00	31,504,528.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,100,000.00	30,904,528.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		600,000.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	38,892,144.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	89,391,426.60

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,592,503.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	225,592,503.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,592,503.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,448,400.00
210104	Урамшуулал	1,448,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,478,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,478,950.00
2105	Нормативт зардал	12,076,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,376,400.00
210502	Хоол, хүнс	1,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	252,000.00
210702	Дотоод албан томилолт	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,036,753.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,036,753.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,592,503.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	225,592,503.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	218,190,003.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,402,500.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ч.Батдэлгэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 24–ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гурванзагал сум нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих жил

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2020 онд Гурванзагал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Гурванзагал сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 2,086,361.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 41,727.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 2,019,114.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 40,382.3 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 504735.0 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	81,897.3	247,110.7	165,213.4
Авлага	185,008.1	160,596.2	-24,411.9
Урьдчилгаа			
Бараа материал	195,235.5	242,688.6	47,453.1
Үндсэн хөрөнгө	2,840,346.0	3,156,826.5	316,480.5
Нийт хөрөнгө	3,302,487.0	3,807,222.0	504,735.0
Өр төлбөр	2,830.2	723.7	-2,106.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,299,656.8	3,806,498.3	506,841.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,302,487.0	3,807,222.0	504,735.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 247,110.7 мянган төгрөг болж 165,213.4 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн татварын орлого давсан, сум хөгжүүлэх сангаас тайлант хугацаанд зээл олгогдоогүй зөвхөн зээлийн эргэн төлөлт төвлөрсөн, төвлөрүүлэх шилжүүлгийн дүн нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Нийт авлага 160,596.2 мянган төгрөг болж 24,411.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд сум хөгжлийн сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл олгоогүй мөн зээлийн авлагын барагдуулалт хийснээс тус тус шалтгаалсан байна. Одоогоор нийт авлагын 99.0 хувийг буюу 159,011.3 мянган төгрөг нь тус сангийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 242,688.6 мянган төгрөг болж өмнөх оноос 47,453.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Эрүүл мэндийн төв, Засаг даргын тамгын газар болон бусад байгууллагууд Ковид-19 цар тахлын тархалттай холбоотой хэрэглэгдэх материал эм эмнэлгийн хэрэгсэл авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,156,826.5 мянган төгрөг болж 316,480.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 322,228.2 мянган төгрөгөөр Сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүдэд ариун цэврийн байгууламж баригдсан, Засаг даргын тамгын газарт Автомашин худалдан авсан, урсгал төсвийн худалдан авалтаар 34302,3 мянган төгрөгийн хөрөнгө олж авсан болон тамгын газрын 40,050.0 мянган төгрөгийн автомашин акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 723.7 мянган төгрөг болж 2,106.5 мянган төгрөгөөр буурсан нь төлбөр тооцоо барагдуулснаас шалтгаалжээ.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,806,498.3 мянган төгрөг болж 506,841.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үр дүнгийн нийт орлого өмнөх оноос 278,525.9 мянган төгрөгөөр буюу 121.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 642,347.5 мянган төгрөгөөр буюу 32.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хэлмэгдэгсдийн нөхөн олговорт 200,000.0 мянган төгрөг дээд шатны төсвийн захирагчийн санхүүжилтээр олгосон, мөн цалин нийгмийн даатгалын шимтгэл, эм эмнэлгийн хэрэгслийн зардал өссөнөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,925,600.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,925,600.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 134,641.0 мянган төгрөгөөр бууруулж 1,790,959.4 мянган төгрөгөөр баталсан байна

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,790,959.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 991,796.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 679,112.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14,298.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 34,100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 71,652.6 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Төсвийн бодит гүйцэтгэлээр нийт 1,651,678.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос улсын төсвөөс 993,558.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 34,254.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 623,865.1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч, 87,244.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 30,342.1 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,579,813.8 мянган төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 26,671.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 22,516.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 22,520.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 21,159.7 мянган төгрөгөөр, бусад зардлыг 118,277.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Гурванзагал сум нь 2020 онд 30,630.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 86,087.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 281.1 хувиар биелүүлсэн байна.



Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 218,190.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,402.5 мянга, нийт 225,592.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Эрүүл мэндийн төв 12,877.7 мянга, Соёлын төв 300.0 мянга, Засаг даргын тамгын газарт 11,714.8 мянга, иргэдийн төлөөлөгчийн хуралд 201,000.0 мянга, нийт 225,592.5 мянган төгрөгийг 100 хувь зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 10 мэдээлэл хугацаа хоцроон, үнэ төлбөргүй ирсэн 93,453,009 төгрөгийн 4 хөрөнгийн гүйлгээг, сумын Соёлын төвийн тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 39 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна. Мөн 6 ширхэг 4,427,078 төгрөг 33 мөнгөний хөрөнгийн орлого, мөн нэгтгэсэн тайлангийн онд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 87 мэдээллийг хугацаандаа, мөнгөн дүнгүй 62 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгах 1 албан шаардлага, 3,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	0	1	0	0	0	100
Зөвлөмж	1	3,000.0	1	3,000.0	0	0	100
Нийт дүн	2	3,000.0	2	3,000.0	0	0	100



3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,602.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 620.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 400.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 19,451.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 130.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Гурванзагал сумын Соёлын тавийн бүртгэл тайланд 620.0 мянган төгрөгийн газрыг бусад хөрөнгөнд бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар он дамжсан авлага үүсгэсэн тул 1 төлбөрийн акт, сум хөгжлийн сангийн авлага барагдуулалттай холбоотой зөрчилд 1 албан шаардлага, е баримтгүй худалдан авалт хийсэн болон санхүүгийн тайланд устгах бичилт хийх талаар 2 зөвлөмж хүргүүллээ.

1. Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант жилийн 0,4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг цалингаас суутгалгүйгээр авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Сум хөгжлийн сангийн зээлийн хугацаа хэтрэлттэй 5 зээлдэгчийн 19,4 сая төгрөгийн авлага байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих" журмын 1.6.2-т "Зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна." гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн санхүүгийн тайлангийн устгах бичилттэй холбоотой болон е-баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сумын нийт дотоод устгалын дүн нь 711,109,463.37 төгрөг бөгөөд дээрх устгалыг бүрэн хийсэн байна. Харин орлого, зардлын нийт 860,631,690.04 төгрөгийн гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахаар төлөвлөсөн байна. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тус устгалын бичилтийг анхаарч үзье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Менежментийн захидал



Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн орлого, зардлын гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн тусгах.

1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Гурванзагал сумын Соёлын төвийн худалдан авалтын анхан шатны баримтаас хөөн шалгахад 95.8 хувьтай байгаа бөгөөд 130.3 мянган төгрөгийн Е-баримтыг хавсаргаагүй байна.

2.2 Эрсдэл: Журам хэрэгжихгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах”, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Гурванзагал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/5/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Гурванзагал сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант жилийн 0,4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг цалингаас суутгалгүйгээр авлага үүсгэсэн	400.0	Төлбөрийн акт	Засаг дарга	Ч.Батдэлгэр
2	Сум хөгжлийн сангийн хөрөнгөнөөс сумын 5 иргэд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхээр олгосон хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл 19,5 сая төгрөгийн зээл одоог хүртэл барагдуулаагүй байна.	19,451.7	Албан шаардлага	Засаг дарга	Ч.Батдэлгэр
3	Сумын төсөвт байгууллагууд нь тайлант онд 78 мэдээлэл шилэн дансанд хугацаа хоцроон байршуулсан, нийт 97,9 сая төгрөгийн орлого болон хөрөнгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.	0	Албан шаардлага	Засаг дарга	Ч.Батдэлгэр
4	Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь устгах бичилтийг бүрэн хийхэд анхаарч ажиллах.	0	Зөвлөмж	Засаг дарга	Ч.Батдэлгэр
5	Соёлын төвийн е-баримтын бүрдэл 95,8 хувьтай бөгөөд 130,3 мянган төгрөгийн е-баримт хавсаргаагүй байна.	130.3	Зөвлөмж	Засаг дарга	Ч.Батдэлгэр
6	Гурванзагал сумын Соёлын тавийн бүртгэл тайланд 620.0 мянган төгрөгийн газрыг бусад хөрөнгөнд бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.	620.0	Залруулга	Засаг дарга	Ч.Батдэлгэр
Дүн		20,602.0			

